



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/527

Арвайхээр сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 2 нэгж талбарыг эзэмшигчдийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Газар эзэмших эрх шинээр олгох тухай" А/301 дүгээр захирамжийн Гүнчимэгтэй ХХК-тай холбогдох хэсэг, 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Газар эзэмших эрх шинээр олгох тухай" А/840 дүгээр захирамжийн хавсралтын М.Мөнхбаяртай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 1054

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 415/27 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСАД ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/Д	Газар эзэмшигчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м ²) газраас	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м ²) газрыг	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1	Гүнчимэгтэй ХХК	3550532	5-8 давхар нийтийн орон сууц	1370	Топ гео техник ХХК	6011756	5-8 давхар нийтийн орон сууц	1370	13-р баг, Ноён-4 гудамж, 402 тоот	7 жил
2	М.Мөнхбаяр	ЙЭ70032318	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	2500	Г.Тогтуунбаяр	ЙЮ75063036	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	2500	12 дугаар баг, Үйлдвэрлэл-4 гудамж, 417 тоот	11 жил